

## ҮР ДҮНД СУУРИЛСАН ДУНД ХУГАЦААНЫ ТӨСВИЙН САНАЛЫН МАЯГТ БӨГЛӨХ ЗААВАР

### 1. Төсвийн саналын хамрах хүрээ

УИХ-аас баталсан “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх 2024 оны төсвийн төсөл, 2025 ба 2026 оны төсвийн төсөөллийг үр дүнд суурилсан арга зүйг баримтлан энэхүү зааврын дагуу боловсруулна. Энэ маягт нь Төсвийн ерөнхийлөн захирагч **Эрүүл мэндийн сайдад** хамаарах улсын болон эрүүл мэндийн даатгалын сангийн төсөвт хамаарна. Ингэхдээ төсөв хооронд цэвэрлэгдэх шилжүүлгийн зардлуудыг харгалзахгүй.

### 2. Гүйцэтгэлд суурилсан дунд хугацааны төсвийн саналын маягт бөглөх заавар

Үр дүнд суурилсан төсөвлөлтийн арга зүйг ашиглан дараах маягтуудын дагуу боловсруулж ирүүлнэ.

- **ҮДСДХТ МАЯГТ 1:** - “Хөтөлбөрийн үр дүн, түүний шалгуур үзүүлэлтүүд”
- **ҮДСДХТ МАЯГТ 2:** – “Төсвийн санал эдийн засгийн ангиллаар”
- **НЭГТГЭЛ МАЯГТ 3:** – “Төсвийн нэгтгэл”

Дээрх маягтуудыг бөглөхдөө дараах зааврыг баримтална:

#### 1.1 **ҮДСДХТ МАЯГТ 1: “Хөтөлбөрийн үр дүн, түүний шалгуур үзүүлэлтүүд”-ийг боловсруулах заавар**

Төсвийн тухай хуулийн 33.2.5-д заасны дагуу ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт нь Монгол Улсын 2024 оны төсвийн тухайн хуулийн нэгдүгээр хавсралт болж батлагдана. Энэ маягыг дараах байдлаар бөглөнө.

**“Бодлогын үндэслэл” [1-4]** – Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай(ХБТТУТ) хуулийн 4.1.6, 4.1.8, 4.1.9-д заасан баримт бичиг буюу Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл (МУХТЖҮЧ), Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (ЗГҮАХ) болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд заасан ТЕЗ-ийн хэрэгжүүлэх тухайн хөтөлбөрт холбогдох заалтыг сонгож оруулна.

**“Төсвийн хөтөлбөрийн ангилал, хүрэх үр дүн” [5-8]** багануудад төсвийн хөтөлбөрийн кодыг сонгон оруулна. *Төсвийн хөтөлбөрийн хүрэх үр дүн [8]* баганад оруулах үр дүнг тодорхойлохдоо “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан холбогдох хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт, түүний суурь болон зорилтот түвшнийг харгалзан үзнэ. Хэрэв “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд тухайн хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт тусгагдаагүй бол хөтөлбөрийг хариуцсан бодлогын мэргэжилтэн нь Эдийн засаг хөгжлийн сайдын 2022

оны 12 сарын 28-ны өдөр А/167 тоот тушаалаар батлагдсан үр дүнд суурилсан “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу боловсруулан хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн суурь ба зорилтот түвшнийг батлагдсан төсвийн хязгаарт багтаан тооцож, тодорхойлно. Ингэхдээ нэг бодлого хөтөлбөрт 3-с дээшгүй үр дүнг тодорхойлохыг анхаарна уу.

**“Бодлогын өөрчлөлт” [9-10]** багануудад доорх бодлогын төрлөөс сонгоно. Үүнд:

а. *Бодлогын өөрчлөлтгүй* - *Одоо хэрэгжиж байгаа бодлого*: ТЕЗ тухайн төсвийн хөтөлбөрийн хүрээнд одоо хэрэгжүүлж байгаа түр болон урт хугацааны бодлого байна. 2024 оноос зогсоож байгаа бодлого

б. *Бодлогын өөрчлөлттэй* – *Шинэ бодлого*: Энэ нь тухайн ТЕЗ шинээр санаачлан хэрэгжүүлж байгаа бодлогууд орно.

в. *Бодлогын өөрчлөлттэй* – *Өмнөх бодлогын өөрчлөлт*: Энэ нь тухайн ТЕЗ-ийн хэрэгжүүлж байгаа бодлогод ямар нэг төсвийн нөлөөлөлтэй өөрчлөлт оруулсан тохиолдолд сонгоно.

*Бодлогын мэдэгдэл [10]* баганад одоо хэрэгжиж байгаа болон бодлогын өөрчлөлттэй холбоотой хууль журам, тогтоол шийдвэр, үйл ажиллагааны тайлбарыг гараар шивж оруулна.

**“Зорилтот хүн ам” [11-14]** багануудад жендерийн хүртээмжийн талаар асуулгын хэсгийг сонгох бөгөөд *Үр шим хүртэгчид [11]* баганад тухайн бодлогын хүрээнд үр шим хүртэж байгаа хүн ам зүйн хэсгийг гараар шивж оруулна.

**“Хөтөлбөр хэрэгжих хугацаа” [15-16]** багануудад тухайн бодлоготой холбоотойгоор хэрэгжиж байгаа хугацааг тодорхойлно. Байнгын шинжтэй хөтөлбөрийн хувьд Байнга гэсэн сонголтыг сонгож болно. Харин эхлэх он болон үргэлжлэх жил нь тодорхой бодлого хөтөлбөрийн хувьд эхлэх он болон үргэлжлэх хугацааг жилээр нь сонгож оруулна. Хэрэгжиж дуусаж байгаа хөтөлбөрийн хувьд дуусах оныг 2023 оноор сонгон оруулна. Энэ тохиолдолд зөвхөн 2022 оны гүйцэтгэл болон 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэл баганад дүн бичигдэхийг анхаарна уу.

**“Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт” [17-19]** багануудад тухайн бодлого хөтөлбөрийн үр дүнг илтгэх шалгуур үзүүлэлтийг гараар шивж оруулна. Ингэхдээ дараах зарчмуудыг баримтална:

- Монгол Улсын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд үндэслэх;
- Монгол Улсын 2024 оны жилийн төсвийн хязгаарт нийцсэн, хэрэгжихүйц байх;
- Нөхцөл байдлын дүн шинжилгээнд үндэслэсэн бөгөөд гүйцэтгэл нь мэдээллийн эх сурвалжаар баталгаажсан байх;

- Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшнийг тодорхойлохдоо харьяа доод шатны байгууллагаас санал авч, зөвшилцөх;
- Өнгөрсөн 3 жилийн батлагдсан төсөв, төсөв гүйцэтгэлийн дунджийг харгалзах.

**“Суурь түвшин” болон “Зорилтот түвшин” [20-24]** багануудад шалгуур үзүүлэлтийн *Суурь түвшин [21]* баганад тухайн шалгуур үзүүлэлтийн хамгийн сүүлийн байдлаар хэмжсэн түвшин, *Суурь он [20]* баганад суурь түвшний хэмжсэн он болон *Зорилтот түвшин [22-24]* баганад дараагийн 3 жилийн хүрэх түвшнийг тус бүр гараар шивж оруулна.

**“Мэдээллийн эх сурвалж” [25-26]** багануудад тухайн шалгуур үзүүлэлтийн үр дүнг тодорхойлох эх сурвалжийн мэдээллийг оруулна. Мэдээллийн эх сурвалжийн нэр [25] баганад тухайн шалгуур үзүүлэлтийг гаргасан тайлан мэдээний нэр болон аль хэсэгт гарч байгааг тодорхой шивж оруулна. Харин *Мэдээлэл боловсруулагч, хариуцагч байгууллага [26]* баганад тухай мэдээ тайланг эрхлэн гаргадаг байгууллагын нэр болон холбогдох цахим хаягийг гараар шивж оруулна.

## **1.2 ҮДСДХТ МАЯГТ 2: “Төсвийн санал эдийн засгийн ангиллаар”-ийг боловсруулах заавар**

Энэ маягт нь төсвийн хөтөлбөр тус бүрийг бодлогын төрлөөр, (а. Бодлогын өөрчлөлтгүй - одоо хэрэгжиж байгаа, б. Бодлогын өөрчлөлттэй - шинэ бодлого, в. Бодлогын өөрчлөлттэй - Өмнөх бодлогын өөрчлөлт) төрөл тус бүрт хамаарах төсвийн дүнгээр харуулна.

**“Төсвийн ангилал” [1-2]** баганад Сангийн сайдын “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 2015 оны 7 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаас тухайн ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ болон эдийн засгийн ангиллын кодыг сонгож оруулна. Ингэхдээ эдийн засгийн хураангуй ангиллыг (2101 – Цалин хөлс болон нэмэгдэл урамшил ангилалд байгаа дүнг тавих буюу 210101 -Үндсэн цалин гэсэн дэлгэрэнгүй ангиллаар задалж шивэхгүй) сонгож оруулна. Түүнчлэн шинэ мөр нэмэхдээ өмнөх мөрийн томъёог хуулж тавихыг анхаарна уу. Жишээ нь: Эдийн засгийн ангиллын мөр нэмсэн үед өмнөх эдийн засгийн ангилалтай мөрийн код, нэрийг шинэ мөрөнд хуулсны (copy, paste) дараа эдийн засгийн ангиллын кодыг сонгоно.

**“Бодлогын төрөл” [3]** баганад Маягт 1-ийн [9] баганад оруулсны дагуу бодлогын төрлийг сонгож оруулах бөгөөд тухайн бодлогын хүрээнд хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн төсвийн дүнг оруулна. Тухайлбал; 71601 – Нийгмийн эрүүл мэнд хөтөлбөр нь ТЕЗ-ийн хүрээнд хэрэгжүүлж байгаа нийт төсвийн дүнгээр шивэгдэхгүй харин бодлогын өөрчлөлт байгаа эсэхээс хамаарч

*а. Бодлогын өөрчлөлтгүй - Одоо хэрэгжиж байгаа бодлого;*  
*б. Бодлогын өөрчлөлттэй – Шинэ бодлого;*

*в. Бодлогын өөрчлөлттэй – Өмнөх бодлогын өөрчлөлт зэрэг төрөл тус бүрийн төсвийн дүн оруулах болохыг анхаарна уу. Хэрэв тухайн хөтөлбөр нь ямар нэг бодлогын өөрчлөлтгүй бол төсөв нь нийт дүнгээр а. Бодлогын өөрчлөлтгүй - Одоо хэрэгжиж байгаа бодлого мөрөнд шивэгдэж болно.*

**“Төсвийн дүн” [4-8]** баганад төсвийн дүнгүүдийг он оноор гараар шивж оруулна. Ингэхдээ эдийн засгийн хураангуй ангиллын мөрөнд төсвийн дүнг шивэх бөгөөд тэдний нийлбэр дүнгээр зориулалт, арга хэмжээний ангилал мөрөнд нэгтгэгддэг байхаар томъёо оруулсан болно. Үүний нэг адил зориулалт, арга хэмжээнүүдийн нийлбэр дүн хөтөлбөрийн арын харгалзах баганад нэгтгэгддэг байхаар томъёо оруулсан болно. Түүнчлэн шинэ мөр нэмэхдээ өмнөх нүдэнд байгаа томъёог хуулж тавихыг анхаарна уу.

**“Тайлбар” [9]** баганад тооцооллыг хэрхэн хийсэн тайлбар, тооцоололд авч үзсэн хүчин зүйлсийн тайлбарыг гараар шивж оруулна.

### **1.3 НЭГТГЭЛ МАЯГТ 3: – “Төсвийн нэгтгэл”**

Энэ маягт-д ТЕЗ-ийн хэрэгжүүлэх нийт хөтөлбөр, түүний хүрэх үр дүн болон бодлогын төрөл тус бүр дээр төсөвлөгдсөн дүнг нэгтгэж гаргана.

**“Хөтөлбөрийн ангилал” [1-2]** баганад Маягт 1 бөглөсний дагуу ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийг сонгож оруулна.

**“Бодлогын өөрчлөлт” [3-4]** багануудад бодлогын төрлийг Маягт 1-д бөглөсний дагуу сонгож оруулна.

**“Төсвийн дүн” [4-8]** баганад төсвийн дүн автоматаар бөглөгдөж орох тул шивэх шаардлагагүй, төсвийн дүнгүүд үнэн зөв гарсан эсэхийг хянана. Ингэхдээ [1-4] баганын мэдээллийг зөв сонгож оруулсан байх хэрэгтэйг анхаарна уу.

**“Төсвийн хөтөлбөрийн хүрэх үр дүн” [10-11]** багануудад төсвийн хөтөлбөрийн бодлогын төрлийн дагуу Маягт 1-т тодорхойлогдсон хүрэх үр дүнг авч гараар оруулна. Ингэхдээ бодлогын төрөл бүрээр 3-аас ихгүй үр дүн байхыг анхаарна уу.

--oOo--